



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/113

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/372 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллах зорилгоор ТУШААХ НЬ:

1. Дэлхийн эрүүл мэндийн "Тархины харвалттай тэмцэх өдөр"-ийг угтсан 14 хоногийн аяныг 2017 оны 10 дугаар сарын 16-29-ий өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	О.Ганчулуун	Эмчилгээ эрхэлсэн дэд захирал
Нарийн бичгийн дарга:	В.Баярмаа	Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал
Гишүүд:	Д.Дэжидмаа	Поликлиникийн эрхлэгч
	О.Оюунтөгс	Сувилахуйн албаны дарга
	С.Ариунболд	Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн
	Г.Уянга	Чанарын менежер
	Ш.Сугармаа	Хүний нөөцийн мэргэжилтэн
	М.Даваадулам	Хүний нөөцийн мэргэжилтэн
	Б.Ичинхорлоо	Асрамжийн клиникийн үзлэгийн эмч
	Ж.Гантулга	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд даалгах нь:

2.1 Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/372 дугаар тушаалтай сайтар танилцаж хэрэгжүүлэн ажиллах;

000364

2.2 Аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гаргаж Ерөнхий захирлаар батлуулан хэрэгжүүлэн ажиллах;

2.3 Аяны хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг 2017 оны 11 дүгээр сарын 05-ны дотор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлэх;

3. Энэ тушаалын хэрэгжилтийн талаар Удирдлагын зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 19-ний хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч О.Ганчулуунд үүрэг болгосугай.

4. Аяны үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийг санхүүгийн баримтанд тулгуурлан олгохыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Энжжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ